



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН
ИХ СУРГУУЛИЙН РЕКТОРЫН
ТУШААЛ

2026 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/102

Улаанбаатар хот

Оюутан элсүүлэх журам батлах тухай

Монгол Улсын “Дээд боловсролын тухай хууль”-ийн холбогдох заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/143 тоот тушаалаар батлагдсан “Оюутан элсүүлэх журам” СЭЗИС-ийн элсэлтийн нэгдсэн бодлогод үндэслэн ТУШААХ нь:

1.Бакалаврын зэрэг олгох үндсэн болон олон улсын хамтарсан хөтөлбөрт оюутан элсүүлэх журмыг баталсугай.

2.Энэхүү журам батлагдсантай холбогдуулан элсэлтийн үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Элсэлтийн комиссын дарга (Б.Мөнхзаяа)-д, элсэлтийн системийн бэлэн байдлыг хангаж хяналт тавьж ажиллахыг Мэдээлэл, технологийн албаны дарга (Б.Батжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

3.2026-2027 оны хичээлийн жилд оюутан элсүүлэхтэй холбоотой журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бакалаврын сургалт, судалгаа хариуцсан проректор (Б.Мөнхзаяа)-т, холбогдох зардлыг зохих төсвөөс зарцуулахыг Эдийн засаг, санхүүгийн албаны дарга (Д.Өлзиймаа)-д зөвшөөрсүгэй.

РЕКТОР  Б.МӨНХБАЯР





СЭЗИС-ийн Ректорын 2026 оны 03 дүгээр сарын 18-ний өдрийн А/102 дугаар тушаал Хавсралт №1

САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛИЙН БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРТ ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг.Ерөнхий зүйл

1.1.Санхүү Эдийн Засгийн Их Сургууль нь 2031 он хүртэлх хөгжлийн стратегийн хүрээнд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, дижитал, энтрепренер их сургууль болох зорилт дэвшүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд сургалт, судалгаа, оюутны үйлчилгээнд хиймэл оюун ухааныг (AI) үр ашигтай нэвтрүүлсэн AI-first их сургууль болох хөгжлийн чиглэлийг баримтална.

1.2.Бакалаврын хөтөлбөрт 2026-2027 оны хичээлийн жилд оюутан элсүүлэхэд Монгол Улсын “Дээд боловсролын тухай хууль”, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/143 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Оюутан элсүүлэх журам”, 2026 оны Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/34 “Босго оноо тогтоох тухай” тушаал, элсэлтийн нэгдсэн бодлого болон энэхүү журмыг баримтална.

1.3.Гадаадын иргэнийг элсүүлэх асуудлыг “СЭЗИС-ийн бакалаврын хөтөлбөрт гадаад иргэнийг элсүүлэх журам”-аар, дипломын сургалт төгссөн элсэгчдийг “СЭЗИС-ийн бакалаврын хөтөлбөрт дэвшүүлэн суралцуулахад баримтлах журам”-ын дагуу элсүүлнэ.

Хоёр.Бакалаврын хөтөлбөр, элсэлтийн шалгуур

2.1.СЭЗИС нь хөдөлмөрийн зах зээл, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлсэн мэдлэг, ур чадвар олгох BBA, BS, LLB, BA гэсэн бакалаврын зэргийг дараах 16 мэргэжлээр оюутан элсүүлнэ. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. СЭЗИС-ийн бакалаврын зэрэг, мэргэжил

№	Олгох зэрэг	Англи нэршил	Суралцах багц цаг	Хамаарах мэргэжил
1	Бизнесийн удирдлагын бакалавр	Business Administration - BBA	120	Бизнесийн удирдлага, Даатгал, Маркетинг + AI, Нягтлан бодох бүртгэл, Олон улсын нягтлан бодох бүртгэл - ACCA, Олон улсын нягтлан бодох бүртгэл - CGMA, Санхүү банк, Энтрепренешип + AI, Санхүүгийн манлайлал + AI, Олон улсын худалдаа + AI

2	Шинжлэх ухааны бакалавр	Bachelor of Science - BS	125	Мэдээллийн систем + AI, Эдийн засаг
3	Эрх зүйн бакалавр	Bachelor of Laws - LLB	133	Эрх зүй
4	Нийгмийн ухааны бакалавр	Bachelor of Arts - BA	120	Аялал, жуулчлал, Зочлох үйлчилгээний менежмент, Нийгмийн инновац

2.2. Суралцагч нь элсэлтийн шалгуур хангасан тохиолдолд өөрийн сонирхол, зорилгод нийцүүлэн сургалтын дараах хэлбэрээс сонгон суралцах боломжтой. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. СЭЗИС-ийн бакалаврын хөтөлбөрт суралцах хэлбэр

№	Суралцах хэлбэр	Тайлбар
1	Үндсэн	СЭЗИС-ийн сургалтын онцлог арга зүй, технологиор суралцах уламжлалт сургалтын хэлбэр.
2	Хамтарсан	Гадаадын хамтын ажиллагаатай сургуулиудаас сонгон хоёр сургуулийн диплом авах боломжтой сургалтын хэлбэр.
3	Мэргэшсэн	Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэргэшсэн зэрэг (ACCA, CGMA)-ийг СЭЗИС-ийн бакалаврын зэрэгтэй хамтатган суралцах хэлбэр.
4	Интерактив	Асуудал шийдвэрлэх, төсөл боловсруулах, багаар ажиллах зэрэг идэвхтэй арга зүйд суурилсан практик чиглэлийн сургалтын хэлбэр.
5	BTEC	Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн диплом болон СЭЗИС-ийн бакалаврын зэрэг хослон эзэмших сургалтын хэлбэр.
6	Rotation	3 жилийн хугацаанд СЭЗИС болон гадаадын 3 их сургуульд дамжин олон соёлын орчинд суралцах сургалтын хэлбэр.
7	Хос	Хоёр мэргэжлээр зэрэг суралцаж, салбар дундын хандлага, ур чадвар эзэмших боломжтой сургалтын хэлбэр.
8	+ MBA	Бакалавр болон Бизнесийн удирдлагын магистрын хөтөлбөрийг богино хугацаанд зэрэг эзэмших боломжтой сургалтын хэлбэр.

2.3. СЭЗИС-ийн бакалаврын хөтөлбөрт элсэгч нь дараах шаардлагыг хангасан байна.

- Бүрэн дунд боловсрол эзэмшсэн байх;
- Мэргэжлийн чиглэлд харгалзах ЭЕШ-ын босго онооны шалгуурыг хангасан байх;
- Элсэлтийн цахим системд заасан хугацаанд бүртгүүлсэн байх;


2.4.Бакалаврын хөтөлбөрт элсүүлэх элсэгчийн хяналтын тоо, сургалтын төлбөрийг Удирдах зөвлөл тогтооно.

2.5.Мэргэжил бүрд харгалзах элсэлтийн шалгуурыг Хавсралт 1-ээс харна уу.

2.6.Олон улсын хамтарсан хөтөлбөрт элсэгч нь суралцах гадаад хэлийг эхэлж сонгох ба нэг жил сурсны дараа хамтарсан сургуулиа сонгоно, мэдээллийг Хавсралт 2-оос харна уу.

2.7.Мэргэжил, хөтөлбөрийн танилцуулга, мэргэжлийн үнэ төлбөргүй оношилгоо, элсэлтийн зөвлөгөөг дараах хуваарийн дагуу авах боломжтой. (Хүснэгт 3)

Хүснэгт 3. Мэргэжлийн оношилгоо, элсэлтийн мэдээлэл, зөвлөгөө

Хэлбэр	Байршил	Ажиллах хуваарь
Танхим	СЭЗИС-ийн хичээлийн С байр 103 тоот	2026/04/22-ы 2026/07/03-ы өдрийн хооронд ПҮРЭВ, БААСАН гараг бүрийн 14:00-17:30 цаг
Цахим	Цахим мэдээлэл өгөх холбоос 	

Гурав.Элсэлтийн бүртгэл , тавигдах шаардлага

3.1.Бакалаврын хөтөлбөрийн элсэлтийн бүртгэл admission.ufe.edu.mn цахим хаягаар 2026.04.22-2026.06.28-ны өдрийн хооронд явагдана.

3.2.Элсэлтийн системд бүртгүүлэхэд Боловсролын үнэлгээний төв (БҮТ)-ийн элсэлтийн ерөнхий шалгалт (ЭЕШ)-ын бүртгэлийн дугаарыг ашиглана.

3.3.Элсэлтийн ерөнхий шалгалтын “Батламж хуудас” нь шалгалт өгснөөс хойш 2.5 жилийн хугацаанд хүчинтэй. Хоёроос дээш удаа ЭЕШ өгсөн тохиолдолд өндөр оноогоор элсэлтийн шалгуур хангасанд тооцож жагсаалтад оруулна.

3.4.Элсэлтийн үйл ажиллагаатай холбоотой элсэлтийн журам, заавар, элсэгчдэд зориулсан цахим зөвлөх үйлчилгээний удирдамж болон холбогдох мэдээллийг СЭЗИС-ийн элсэлтийн системд (admission.ufe.edu.mn) байршуулна.

3.5.Гадаадад суралцаж төгссөн, эсвэл олон улсын шалгалт өгсөн бүртгүүлэгчийн шалгалтын мэдээлэл БҮТ-д бүртгэгдэж, баталгаажсан байна.

3.6.Олон улсын хөтөлбөрийн шалгалтын оноог тооцохдоо БШУЯ-ны 2021 оны А/347 тоот тушаалаар баталсан “Олон улсын шалгалт үнэлгээг Монгол Улсын ЭЕШ-ын үнэлгээтэй дүйцүүлэн тооцох тухай журам”-ыг баримтална.

3.7.Бүртгүүлэгч элсэлтийн системд (admission.ufe.edu.mn) зааврын дагуу шаардлагатай мэдээллээ үнэн зөв оруулж, баталгаажуулна. Системд алдаатай мэдээлэл оруулснаас үүсэх асуудлыг СЭЗИС-ийн Элсэлтийн комисс хариуцахгүй.

3.8.Бүртгэлийн хураамж 50,000 төгрөг байна. Бүртгэлийн хураамжид СЭЗИС-ийн цахим зөвлөх үйлчилгээний төлбөр багтсан болно. Цахим зөвлөх үйлчилгээний удирдамжийг Хавсралт 3-аас харна уу.

Дөрөв.Зохион байгуулалт

4.1.СЭЗИС-ийн бакалаврын хөтөлбөрийн элсэлтийн үйл ажиллагааг дараах гурван үе шаттайгаар зохион байгуулна.

4.2.Онооны жагсаалт гарах үе шат

4.2.1.Бүртгүүлэгч нь 2026 оны 6-р сарын 29-ий өдөр 13:00 цагаас элсэлтийн системээр нэвтрэн /admission.ufe.edu.mn/ онооны жагсаалттай танилцана.

4.2.2.Нэг элсэгч хэд хэдэн бүлгийн жагсаалтад орж болно. Тэнцсэн, хүлээгдэж буй, тэнцээгүй гэсэн 3 төлөвтэй байна. Онооны жагсаалтыг элсэлтийн шалгуур хоёр хичээлийн шалгалтын дундаж онооны эрэмбээр гаргана.

- Бүлэг I: Математик + Англи хэл
- Бүлэг II: Нийгмийн тухай мэдлэг + Англи хэл
- Бүлэг III: Англи хэл+ Монгол хэл
- Бүлэг IV: Англи хэл + Ур чадварын шалгалт
- Бүлэг V: Нийгмийн тухай мэдлэг + Монгол хэл

4.2.3.ЭШ-ын оноо тэнцсэн тохиолдолд гүйцэтгэлийн хувийг тооцон, эрэмбэ тогтооно. Гүйцэтгэлийн хувь тэнцвэл боловсролын гэрчилгээний дундаж оноог чухалчлан харгалзана.

4.3.Мэргэжил, хөтөлбөр баталгаажуулах үе шат

4.3.1.шалгуур хангасан бүртгүүлэгч 6 сарын 29-ий 14:00 цагаас эхлэн онооны жагсаалт, цагийн хуваарийн эрэмбийн дагуу суралцах мэргэжил, хөтөлбөрөө сонгоно.

4.3.2.мэргэжил, хөтөлбөр баталгаажуулах үйл ажиллагааг 2026.06.29-2026.07.03-ны хороонд элсэлтийн цахим системээр зохион байгуулна. Нэг элсэгч нэг мэргэжил, хөтөлбөр сонгох, баталгаажуулах боломжтой.

4.3.3.хугацаандаа мэргэжил, хөтөлбөрөө баталгаажуулаагүй тохиолдолд дараагийн бүртгүүлэгчид сонголт хийх эрх шилжинэ.

4.3.4.суудал баталгаажуулалтын төлбөр болох 500,000 төгрөг төлж, мэргэжил, хөтөлбөрөө баталгаажуулна. “Суралцах эрхийн бичиг”, суралцах гэрээ болон бусад мэдээллийг элсэгчийн имэйл хаягаар хүргэнэ.

4.3.5.суралцах эрхээ цуцлах тохиолдолд суудал баталгаажилтын төлбөрөөс 40% суутгана.

4.3.6.сонгосон мэргэжил, хөтөлбөрийг солих хүсэлтийг Элсэлтийн комисст гаргаж болно. Элсэлтийн шалгуур болон анги дүүргэлтийн мэдээлэлд үндэслэн элсэгчийн хүсэлтийг ажлын 24 цагт багтаан шийдвэрлэнэ. Тухайн мэргэжил, хөтөлбөрийн шалгуур хангаагүй бол хөтөлбөр хооронд шилжих хүсэлтийг Элсэлтийн комисс хүлээн авахгүй.

4.4.Гэрээ байгуулах үе шат

4.4.1.суралцах эрхийн бичиг авсан шинэ элсэгч 1-р улирлын сургалтын төлбөрийн урьдчилгаа 2,500,000 төгрөгийг төлсний дараа сургалтын гэрээ байгуулна. Сургалтын гэрээ байгуулсан элсэгчид англи хэлний түвшин тогтоох болон IQ, EQ шалгалт өгнө.

Тав.Урилгаар элсүүлэх

5.1.Улсын олимпиад, СЭЗИС-ийн нэрэмжит олимпиадад байр эзэлсэн болон урлаг, спортын амжилт үзүүлсэн авьяаслаг сурагчид онооны жагсаалт харгалзахгүй хүссэн мэргэжил, хөтөлбөрт урилгаар элсэн суралцуулна.

5.2.Урилгаар суралцах хүсэлт, амжилтыг нотлох баримт, сургуулийн тодорхойлолтыг 2026.06.13-ы дотор СЭЗИС-ийн “Цахим зөвлөх үйлчилгээ”-ий талбараар хүлээн авч, болзол хангасан элсэгчид 2026.06.19-д суралцах урилгыг гардуулна

5.3.Урилгаар суралцах эрхийг элсэн суралцахыг хүсэж буй мэргэжилд хамаарах ЭЭШ-ын бүлэг дэх хичээлүүдийн үндэсний босго оноог хангасан тохиолдолд хүчинтэй.

5.4.Урилгаар элсэх нөхцөл

Олон улсын болон үндэсний олимпиадад амжилт гаргасан:

- Математикийн олимпиадын эхний 5 байрт шалгарсан сурагч Бүлэг I-V сонгон суралцах;
- Мэдээлэл зүйн олимпиадын эхний 5 байрт шалгарсан сурагч мэдээллийн системийн хөтөлбөрт элсэн суралцах;
- Нийгмийн ухааны олимпиадад эхний 5 байрт шалгарсан тохиолдолд эрх зүй, энтрепренершип, зочлохуй хөтөлбөрт элсэн суралцах;
- Англи хэлний олимпиадад эхний 5 байрт шалгарсан тохиолдолд нийгмийн инновац, аялал жуулчлал, зочлохуй хөтөлбөрт элсэн суралцах;

Урлаг, спортын амжилт гаргасан:

- Олон улсын болон үндэсний урлаг, спортын тэмцээнд медальт байрт шалгарсан тохиолдолд Бүлэг I-V сонгон суралцах;

СЭЗИС-ийн нэрэмжит уралдаан, тэмцээнд амжилт гаргасан:

- СЭЗИС-ийн нэрэмжит математикийн олимпиадын эхний 10 байр эзэлсэн сурагчид Бүлэг I-д хамаарах мэргэжлүүдээс сонгон суралцах;
- СЭЗИС-ийн нэрэмжит англи хэлний олимпиадын эхний 10 байр эзэлсэн сурагчид Бүлэг I-д хамаарах мэргэжлүүдээс сонгон суралцах;
- СЭЗИС-ийн нэрэмжит нийгмийн тухай мэдлэг олимпиадын эхний 10 байр эзэлсэн сурагчид Бүлэг I-д хамаарах мэргэжлүүдээс сонгон суралцах;
- СЭЗИС-ийн нэрэмжит маркетингийн контент уралдаанд эхний 10 байр эзэлсэн сурагчид маркетингийн мэргэжлээр суралцах;

Зургаа.Тэтгэлэг

6.1.СЭЗИС нь нийгмийн хариуцлагын хүрээнд сурах боломж олгох шинэ элсэгчийн тэтгэлгийг “СЭЗИС-ийн шинэ элсэгчид тэтгэлэг олгох” журмын дагуу хүсэлт гаргаж, Элсэлтийн комисс хүлээн авч шийдвэрлэнэ.

6.2.СЭЗИС-ийн босго оноог бүрэн хангасан, суралцах чин хүсэл эрмэлзэлтэй, амжилттай суралцаж байгаа элсэгчид сургалтын төлбөрийн 3 хүртэлх сая төгрөгийн тэтгэлгийг олгоно.

6.3.Шинэ элсэгчийн тэтгэлэгт хамрагдсан элсэгчдэд олгох мөнгөн дүнг 2026-2027 оны хичээлийн жилийн сургалтын төлбөрт тооцно.

6.4.Тэтгэлэг хүсэгчийн хүсэлтийг 2026.06.13-ы дотор СЭЗИС-ийн “Цахим зөвлөх үйлчилгээ”-ий талбараар хүлээн авна.

6.5.Ирүүлсэн материалыг Элсэлтийн комисс шалган 2-р шатанд тэнцсэн элсэгчдэд 2026.06.19-д “Батламж” гардуулна.

Долоо.Бусад

7.1. Элсэлтийн комисс нь “Элсэлтийн комиссын ажиллах журам”-ыг мөрдлөг болгон элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих, элсэхийг хүсэгчийг бүртгэх, хяналтын тоонд багтаан шалгаруулах, ирсэн санал, гомдлыг барагдуулах зэрэг үндсэн үүргийг гүйцэтгэнэ. Элсэлттэй холбоотой аливаа санал, хүсэлтийг элсэлтийн систем (admission.ufe.edu.mn) сайтаар Элсэлтийн комисс хүлээн авч, ажлын 3 хоногт багтаан шийдвэрлэж, хариуг имэйлээр илгээнэ.

7.2.Элсэлтийн бүртгэлийн хураамж, сургалтын урьдчилгаа төлбөрийг Худалдаа хөгжлийн банкны 2612007984 (IBAN MN820004002612007984) тоот дансанд тушаана. Хүлээн авагч - СЭЗИСургууль, (С*****ь), Гүйлгээний утга: Элсэгчийн овог, нэр, регистрийн дугаарыг бичнэ) СЭЗИС-ийн албан ёсны дансанд ороогүй гүйлгээг хувь хүн өөрөө хариуцна.

Бакалавр хөтөлбөрийн элсэлтийн шалгуур Хавсралт №1

№	Мэргэжил, (Боловсролын зэрэг)	Д/Д	Суралцах мэргэжил, хөтөлбөр (хугацаа)	Элсэлтийн шалгуур
1	Аялал жуулчлал (BA)	1.1	Үндсэн хөтөлбөр - (3 жил)	Бүлэг IV - Босго оноо 510 Хамаарах хичээл - Англи хэл болон Ур чадварын шалгалт
		1.2	Олон улсын хамтарсан хөтөлбөр - Англи хэл (1+2+1 жил) - Солонгос хэл (2+1+1 жил) - Япон хэл (2+1+1 жил)	
		1.3	Хос хөтөлбөр (3+1 жил) - Аялал жуулчлал + Зочлох үйлчилгээний менежмент - Аялал жуулчлал + Нягтлан бодох бүртгэл	
2	Бизнесийн удирдлага (BBA)	2.1	Үндсэн хөтөлбөр - (3 жил)	Бүлэг I - Босго оноо 580 Хамаарах хичээл - Математик болон Англи хэл
		2.2	Олон улсын мэргэжлийн дипломтой ВТЕС хөтөлбөр - (3 жил)	
		2.3	Олон улсын хамтарсан хөтөлбөр - Англи хэл (2+2 жил), (3+1 жил) - Хятад хэл (2+2 жил)	
3	Даатгал (BBA)	3.1	Үндсэн хөтөлбөр - (3 жил)	Бүлэг I - Босго оноо 530 Хамаарах хичээл - Математик болон Англи хэл

4	Зочлох үйлчилгээний менежмент (BA)	4.1	Үндсэн хөтөлбөр - (3 жил)	Бүлэг V - Босго оноо 520 Хамаарах хичээл - Нийгэм болон Монгол хэл
		4.2	Олон улсын хамтарсан хөтөлбөр - Англи хэл (1+2+1 жил), (3+1 жил)	
5	Мэдээллийн систем + AI (BS)	5.1	Үндсэн хөтөлбөр - (3 жил)	Бүлэг I - Босго оноо 580 Хамаарах хичээл - Математик болон Англи хэл
		5.2	Олон улсын мэргэжлийн дипломтой ВТЕС хөтөлбөр - (3 жил)	
		5.3	Олон улсын хамтарсан хөтөлбөр - Англи хэл (2+2 жил), (1+3 жил) - Солонгос хэл (2+2 жил)	
6	Маркетинг + AI (BBA)	6.1	Үндсэн хөтөлбөр - (3 жил)	Бүлэг I - Босго оноо 580 Хамаарах хичээл - Математик болон Англи хэл
		6.2	Олон улсын хамтарсан хөтөлбөр - Англи хэл (2+2 жил)	
7	Нягтлан бодох бүртгэл (BBA)	7.1	Үндсэн хөтөлбөр - (3 жил)	Бүлэг I - Босго оноо 580 Хамаарах хичээл - Математик болон Англи хэл
		7.2	Олон улсын хамтарсан хөтөлбөр - Англи хэл (2+2 жил) - Хятад хэл (2+2 жил)	
8	Нийгмийн Инновац (BA)	8.1	Үндсэн хөтөлбөр - (3 жил)	Бүлэг III - Босго оноо 550 Хамаарах хичээл - Англи хэл болон Монгол хэл
		8.2	Олон улсад дамжин суралцах Rotation хөтөлбөр - Англи хэл (1+1+1 жил)	
		8.3	Бакалавр +MBA хөтөлбөр (3+1 жил)	
9	Олон улсын нягтлан бодох бүртгэл ACCA (BBA)	9.1	Олон улсын мэргэшсэн хөтөлбөр - (3,5 жил)	Бүлэг I - Босго оноо 600 Хамаарах хичээл - Математик болон Англи хэл
		9.2	Олон улсын хамтарсан хөтөлбөр - Англи улсын BPP university (2 жил)	
10	Олон улсын нягтлан бодох бүртгэл CGMA (BBA)	10.1	Олон улсын мэргэшсэн хөтөлбөр - (3.5 жил)	Бүлэг I - Босго оноо 580 Хамаарах хичээл - Математик болон Англи хэл
11	Санхүү, банк (BBA)	11.1	Үндсэн хөтөлбөр - (3 жил)	Бүлэг I - Босго оноо 620 Хамаарах хичээл - Математик болон Англи хэл
		11.2	Олон улсын хамтарсан хөтөлбөр - Англи хэл (2+2 жил) - Хятад хэл (2+2 жил)	
12	Санхүүгийн манлайлал + AI (BBA)	12.1	Интерактив хөтөлбөр - (3 жил)	Бүлэг I - Босго оноо 580 Хамаарах хичээл -

				Математик болон Англи хэл
13	Олон улсын худалдаа + AI (BBA)	13.1	Үндсэн хөтөлбөр - (3 жил)	Бүлэг II - Босго оноо 550 Хамаарах хичээл - Нийгэм болон англи хэл
		13.2	Олон улсын хамтарсан хөтөлбөр - Хятад хэл (2+2 жил) - Англи хэл (2+2 жил)	
		13.3	Олон улсад дамжин суралцах Rotation хөтөлбөр - Англи хэл (1+1+1 жил)	
		13.4	Бакалавр +MBA хөтөлбөр (3+1 жил)	
14	Эдийн засаг (BS)	14.1	Үндсэн хөтөлбөр - (4 жил)	Бүлэг I - Босго оноо 620 Хамаарах хичээл - Математик болон Англи хэл (Математик хичээлийн ЭЕШ-ын оноо 600)
		14.2	Олон улсын хамтарсан хөтөлбөр - Англи хэл (2+2 жил)	
15	Эрх зүй (LLB)	15.1	Үндсэн хөтөлбөр - (4 жил)	Бүлэг II - Босго оноо 580 Хамаарах хичээл - Нийгэм болон Англи хэл
		15.2	Олон улсын хамтарсан хөтөлбөр - Хятад хэл (2+2 жил)	
		15.3	Хос хөтөлбөр (4+1 жил) - Эрх зүй + Нягтлан бодох бүртгэл - Эрх зүй + Санхүү, банк	Бүлэг I - Босго оноо 580 Хамаарах хичээл - Математик болон Англи хэл
16	Энтрепренерш ип + AI (BBA)	16.1	Интерактив хөтөлбөр - (3 жил)	Бүлэг I- Босго оноо 580 Хамаарах хичээл - Математик болон Англи хэл
		16.2	Олон улсын хамтарсан хөтөлбөр - Англи хэл (2+2 жил)	

Олон улсын хамтарсан сургуулиудын жагсаалт Хавсралт №2

№	Сургуулийн нэр	Суралцах хугацаа	Суралцах хэл	Санхүү, Банк	Нягтлан бодох бүртгэл	Бизнесийн удирдлага	Энтерпренер	Маркетинг	Худалдаа	Эдийн засаг	Мэдээллийн систем	Эрх зүй	Аялал жуулчлал	Зочлох үйлчилгээ
1	Австрали улс Texila College Australia Melbourne Australia	2+2	Англи		*	*		*						
2	Австрали улс Ozford College Australia Melbourne Australia	2+2	Англи		*	*					*			
3	Их Британи улс BPP ACCA	2+2	Англи		*									
4	АНУ Bay Atlantic University /	1+3	Англи							*	*			
5	Канад улсын Далхаус Их Сургууль	2+2	Англи							*	*			
6	Швейцарь улсын Бизнес, зочид буудлын менежментийн сургууль	3+1	Англи			*								*
7	Финланд Seinäjoki University of Applied Sciences /SeAMK/	2+2	Англи			*	*	*	*					
8	БНСУ-ын Хандонг Глобал Их сургууль	2+2	Англи	*		*		*						
9	БНСУ-ын Вуусонгийн их сургууль	2+2	Англи								*			
10	БНСУ-ын Вуусонгийн их сургуулийн Солбридж ОУБС	2+2	Англи	*		*		*						
11	БНСУ-ын Кёнги их сургууль	2+2	Солонгос								*			
12	Тайвань Азийн Их Сургууль	2+2	Англи	*	*						*			
13	БНХАУ-ын Далианы Политехникийн Их Сургууль	2+2	Хятад						*					

Хавсралт 3.Цахим зөвлөх үйлчилгээний удирдамж

Зорилго: Санхүү Эдийн Засгийн Их Сургууль (СЭЗИС)-ийн бакалаврын хөтөлбөрт элсэхийг хүсэгчдэд мэргэжил сонголт, элсэлтийн журам, бүртгэлийн үйл явцтай холбоотой цогц мэдээлэл болон зөвлөгөөг цахим хэлбэрээр хүргэхэд энэхүү удирдамжийн зорилго оршино.

Хамрах хүрээ: ЕБС-ийн 12-р ангийн сурагчид

Үргэлжлэх хугацаа, хэлбэр: Цахим зөвлөх үйлчилгээг 2026 оны 04 дүгээр сарын 22-оос 2026 оны 06 дугаар сарын 14-ы хооронд СЭЗИС-ийн (admission.ufe.edu.mn)-аар зохион байгуулна.

Цахим зөвлөх үйлчилгээний хөтөлбөр: СЭЗИС-ийн цахим зөвлөх үйлчилгээг сонгосноор дараах хөтөлбөрт хамрагдах боломжтой. Үүнд:

1.Урилгаар элсэгчид материал илгээх: Улсын олимпиад, СЭЗИС-ийн нэрэмжит олимпиадад байр эзэлсэн болон урлаг, спортын амжилт үзүүлсэн авьяаслаг сурагчид дараах болзлыг хангасан тохиолдолд СЭЗИС-ийн бүх мэргэжилд урилгаар суралцуулна.

2.СЭЗИС-ийн нэрэмжит олимпиад, уралдаан: СЭЗИС-ийн элсэлтийн татах үйл ажиллагааны хүрээнд бакалаврын хөтөлбөрүүдээ сурталчлах, мэдээлэл хүргэх, шилдэг элсэгчдийг сонгон шалгаруулах, ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдад математик сэтгэлгээ, нийгмийн тухай мэдлэг болон англи хэлний мэдлэг, маркетингийн контент уралдаанд ур чадвараа сорих боломж олгох.

3.Шинэ элсэгчийн тэтгэлэгт материал илгээх: “СЭЗИС-ийн оюутан элсүүлэх журам”-ыг үндэслэн элсэгчийг амжилттай суралцах хүсэл эрмэлзэлтэй оюутанд сургалтын төлбөрийг дэмжлэг олгох, амжилттай суралцах идэвх, урам зоригийг нэмэгдүүлэх зорилгоор сургалтын төлбөрийн тэтгэлэг олгоно.

4.ЭЕШ-д бэлтгэх цахим хичээл судлах: СЭЗИС-ийн багш нарын элсэлтийн ерөнхий шалгалтад бэлдэх хичээлд хамрагдах боломжтой. Үүнд:

- Математик- Онолын видео хичээл, бататгах дасгал ажлын видео, бие даан бодох бодлого, өөрийгөө сорих сорил;
- Нийгмийн тухай мэдлэг - Онолын видео хичээл, хичээлийн слайд, өөрийгөө сорих сорил;
- Англи хэл- Элсэлтийн ерөнхий шалгалтад зориулсан бие даан гүйцэтгэх ажлууд, олон улсын боловсрол судлалын төв “IEDC” хамтран англи хэлний түвшин тогтоох шалгалтын мэдээлэл, өөрийгөө сорих сорил.

5.Мэргэжил хөтөлбөрийн танилцуулга: СЭЗИС-ийн бакалаврын үндсэн болон олон улсын хамтарсан хөтөлбөрийн мэргэжлийн дэлгэрэнгүй танилцуулга, зөвлөгөө авах боломжтой.

Мэдээлэл авах, холбоо барих албан ёсны сувгууд

1.Цахим хуудас болон сошиал хаяг:

- Элсэлтэд бүртгүүлэх цахим хаяг: <https://admission.ufe.edu.mn>
- Сургуулийн албан ёсны цахим хуудас: www.ufe.edu.mn
- Сургуулийн facebook хаяг: <https://www.facebook.com/ufe.edu.mn>
- Youtube сувар: www.youtube.com/user/TheIFEinfosys
- Linked in: https://twitter.com/ufe_edu_mn
- Twitter: <https://www.linkedin.com/school/ufemongolia/>

2.Цахим шуудан (И-мэйл): Admission_bachelor@ufe.edu.mn

3.Холбоо барих утасны дугаарууд:

- Үндсэн хөтөлбөр: 85058035
- Хамтарсан хөтөлбөр: 85058037
- Мэргэшсэн хөтөлбөр:91999111, 99158505
- Интерактив хөтөлбөр: 99078464
- ВТЕС хөтөлбөр: 99902286, 99189137
- Rotation хөтөлбөр: 99804389, 96509889, 99116287
- Мэдээллийн технологийн алба (Бүртгэлийн системийн асуудлаар): 77350000 (1)
- Санхүүгийн алба (Төлбөрийн асуудлаар): 77774400 (2-1)

Хавсралт 4.Аялал жуулчлал мэргэжлийн ур чадварын удирдамж

Зорилго: Ур чадварын шалгалт нь Аялал жуулчлалын мэргэжлээр элсэгчийн харилцааны эв дүй, асуудлыг шийдвэрлэх байдал, багаар ажиллах чадвар, итгэл, хариуцлагатай хандлагыг тандах зорилготой.

Үндэслэл: Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/143 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын оюутан элсүүлэх журмын дагуу ур чадварын шалгалтыг зохион байгуулна. Уг журмын 3.2.4-т заасныг үндэслэн СЭЗИС-ийн Аялал жуулчлалын мэргэжлийн шинэ оюутан ярилцлага, асуумж гэсэн 2 төрлөөр ур чадвараа үнэлүүлнэ.

Бэлтгэх зүйлс: Элсэгчийн цээж зураг, онооны батламж, иргэний үнэмлэх, асуудлыг тэмдэглэх үзэг, цаас

Гүйцэтгэх даалгаврын төрөл хэлбэр: Ярилцлага, асуумж

Шалгалтын зохион байгуулалт: Цахим, танхим

Хугацаа: Оюутан элсүүлэн баталгаажуулах хугацаа нээгдсэн өдрөөс

Байршил: СЭЗИС-ийн В байр, өргөтгөл

Үнэлгээний шалгуур: Шалгуулагч бүрийн ур чадварын анхны оноо буюу гүйцэтгэлийн хувийг 100 онооноос тооцоолж гаргана.

Үнэлгээ тооцох: Ур чадварын шалгалтад 60 (хэмжээст оноогоор 480) болон түүнээс дээш оноо авсан тохиолдолд тухайн ур чадварын шалгалтад тэнцсэн гэж үзнэ.

Ярилцлага, асуумжийн чиглэл:

1. Харилцааны чадвар: Аялал жуулчлал нь хүний үйлчилгээнд тулгуурладаг тул хамгийн чухал чадвар.

- Уламжлалт болон албан харилцааны хэллэгийг зөв хэрэглэх
- Зочинтой тайван, ойлгомжтой харилцах
- Хэцүү нөхцөлд зөв үг хэллэг сонгож харилцах
- Хоёрдогч хэлний мэдлэг (Англи, Солонгос, Хятад гэх мэт)

2. Асуудал шийдвэрлэх чадвар: Аялал жуулчлалын салбарт гэнэтийн нөхцөл үүсэх тул

- Түргэн шийдвэр гаргах
- Нээлттэй, бүтээлч шийдэл гаргах
- Зөрчил, гомдол барагдуулах ур чадвар

Хавсралт 5. Нэр томъёоны тайлбар

1. “Элсэлтийн комисс” гэж элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахаар томилогдсон ажлын хэсгийг;

2. “Бүртгүүлэгч” гэж СЭЗИС-ийн бакалаврын хөтөлбөрт элсэхээр хүсэлт гаргасан иргэнийг;

3. “Элсэгч” гэж хяналтын тоонд багтан элсэх эрхээ баталгаажуулсан бүртгүүлэгчийг;

4. “Урилгаар элсэх” гэж улсын болон олон улсын математик, физик, мэдээлэл зүй, нийгмийн ухаан, түүх, газар зүй, гадаад хэлний олимпиадад оролцож медальт байранд орж амжилт гаргасан, урлаг спортын авьяасаараа манлайлан амжилт гаргасан онцгой авьяас чадвартай бол, СЭЗИС-ийн нэрэмжит олимпиадын шагналт байранд шалгарсан, болон СЭЗИС-ийн элсэлтийн нэгдсэн бодлогын зорилтот бүлгийн элсэгчийг;

5. “Босго оноо” гэж СЭЗИС-д элсэн суралцах мэргэжлийн элсэлтийн шалгуур хичээлүүдийн элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо;

6. “Жагсаалт” гэж СЭЗИС-ийн Элсэлтийн комиссоос нийт бүртгүүлэгчийн ЭЕШ-ын оноог эрэмбэлэн мэргэжлийн хөтөлбөр тус бүрээр гаргасан БҮТ-ийн бүртгэлийн дугаар бүхий жагсаалт;

7. “Хяналтын тоо” гэж СЭЗИС-д элсүүлэх оюутны тоог;

8. “Улсын олимпиад” гэж Монгол Улсын ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд зохион байгуулагддаг үндэсний хэмжээний олимпиадыг;

9. “Олон улсын олимпиад” гэж ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулагддаг, олон улсын шинж чанартай олимпиадыг;

10. “Шинэ элсэгчийн тэтгэлэг” гэдэг нь нийгмийн хариуцлагын хүрээнд элсэгчдэд “СЭЗИС-ийн тэтгэлэг олгох” журмын дагуу нэг удаа олгож байгаа санхүүгийн мөнгөн дэмжлэгийг;

19. “Элсэлтийн систем” (admission.ufe.edu.mn) гэдэг нь элсэлтийн үйл ажиллагааг удирдах системийг; (мэдээлэл, бүртгэл, онооны эрэмбэ, суралцах эрх, баталгаажилт, цахим төлбөр гэх мэт);

20. “Цахим зөвлөх үйлчилгээ” (admission.ufe.edu.mn) гэдэг нь элсэлтийн үйл ажиллагааг дэмжих цахим талбарыг (мэргэжлийн танилцуулга, ЭЕШ-д бэлтгэх хичээл, сургалтын цахим талбар);

21. “Шилжин суралцах хөтөлбөр” гэж СЭЗИС-ийн Бизнесийн удирлага мэргэжлийн сургалтын төлөвлөгөөний биелэлтийг бүрэн хангаж Втес хөтөлбөрөөр олон улсын их дээд сургуульд шилжин суралцах дипломын хөтөлбөр юм.